

1.БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЦУУЛГА.



Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар нь анх 1989 оны 08 дугаар сарын 08-нд Зөвлөлтийн цэргийн ангиас авсан хотхоныг бүрэн бүтэн байлгах хүмүүс суурьшуулах зориулалтаар “Ашиглалтын өмнөх түр захиргаа” нэртэйгээр байгуулагдаж төрийн удирдлагын бодлого, нийгмийн салбарын үйлчилгээ, төсөв санхүүгийн үйлчилгээ, ХАА, байгаль орчин, газар зохион байгуулалтуудын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байсан.

Одоогоор тус ЗДТГ нь төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний, улс төрийн албан хаагчид, гэрээт ажилчдаас бүрдсэн 27 албан хаагч, босоо удирдлагатай 4 албан хаагч нийт 31 ажиллагсадтайгаар нутгийн удирдлагыг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, хууль эрх зүй, аж ахуйн талаарх дэмжлэг үзүүлж, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах зэрэг хуулиар олгогдсон эрх үүргийг хэрэгжүүлэн төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй, хариуцлагатай, олон нийтийн оролцоог хангасан байх зарчмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.Хүний нөөцийн талаарх үндсэн тоо баримт мэдээлэл:



Сумын ЗДТГазарт 2023 оны 01 сарын 09 ны өдрийн байдлаар 24 удирдах болон гүйцэтгэх, үйлчилгээний ажилтан үүрэг гүйцэтгэж байна.Төрийн албан тушаалын ангиллаар нь:

Төрийн албан тушаалын ангилал	Хүний тоо
Улс төрийн	4
Төрийн захиргааны	10
Төрийн үйлчилгээний	6
Бусад /гэрээт/	4
Бүгд	24

3. Мэрэгжлийн ангилалаар:

Эрх зүйч, нягтлан бодогч, эдийн засагч, багш, хүний их эмч ХАА-н мэргэжилтэн гэсэн мэргэжилтэй ажилтан нийт ажилтны 87.1 хувийг эзэлж байгаа нь ЗДТГ-ын үйл ажиллагааны стратеги, алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд мэрэгшлийн түвшний хувьд, чадамжтай байгааг харуулж байна.

4. Ажлын туршлага:

Нийт ажилтнуудын улсад ажилласан хугацааг 5 жилийн шатлалаар авч үзвэл 26.5 хувь нь 0-5 жил, 36.5 хувь нь 6-10 жил, 9.5 хувь нь 11-15 жил, 12.8 хувь нь 16-20 жил 7.7 хувь нь 21-25 жил 7 хувь нь 26-30 жил ажиллаж байгаа нь харьцангуй тогтвор сууршилтай ажиллаж байна гэж үзэж байна.

5 Хүний нөөцийн төлөвлөлтийн тулгамдсан асуудал.

-Байгууллагын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх.

-Хүний нөөцийн өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлэх чадавхийг сайжруулах.

-Төрийн албан хаагчдын цалин хөлс, урумшууллын системийг боловсронгуй болгох.

-Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах асуудлыг шийдвэрлэх.

-Албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, удирдлагын чадавхийг хөгжүүлэх.

-Төрийн албан хаагчдын хандлага, зан үйлийг төлөвшүүлэх.

-Төрийн жинхэнэ албан хаагчдын тогтвортой ажиллах механизмыг сайжруулах.

-Хүний нөөцийн удирдлагын асуудлаар гадаад дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх.

-Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийг сайжруулах.

-Байгууллагын хөгжлийн хандлагыг хүний нөөцийн хөгжилтэй холбох чадавхийг хөгжүүлэх.